НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 07 сарын 30 өдөр Дугаар А/755 Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 62 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт ашиглаж байгаа болон цаашид шинээр суурилуулахаар төлөвлөж буй хяналтын камеруудыг телехяналтын камерын нэгдсэн системд оруулж, мэдээллийг өргөн хүрээнд зохистой ашиглах, хамгаалах зорилго бүхий "Улаанбаатар хотын телехяналтын нэгдсэн системийг төлөвлөх, зохион байгуулах, мэдээллийг ашиглах журам"-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Журмыг мөрдүүлэх ажлыг зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Инноваци, технологийн асуудал хариуцсан төслүүдийн удирдагч /М.Халиунбат/-д үүрэг болгосугай.

3. Журам батлагдсантай холбогдуулан Нийслэлийн Засаг даргын 2015 оны А/667 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ С.АМАРСАЙХАН

11100003633

Нийслэлийн Засаг даргын 2019 оны
07 дугаар сарын 30-ны өдрийн
А/455 дугаар захирамжийн хавсралт

УЛААНБААТАР ХОТЫН ТЕЛЕХЯНАЛТЫН НЭГДСЭН СИСТЕМИЙГ ТӨЛӨВЛӨХ, ЗОХИОН БАЙГУУЛАХ, МЭДЭЭЛЛИЙГ АШИГЛАХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1.Энэхүү журмын зорилго нь Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт суурилуулсан болон цаашид хэрэгжүүлэхээр төлөвлөж буй телехяналтын камеруудыг нэгдсэн төлөвлөлт, системтэй болгох, хяналт, хамтын ажиллагааг сайжруулж, мэдээллийг өргөн хүрээнд зохистой ашиглах, хамгаалахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

1.2.Улаанбаатар хотын телехяналтын нэгдсэн системийг төлөвлөх, зохион байгуулах, мэдээллийг ашиглах журам нь Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн болон албаны нуцын тухай хууль, Хувь хүний нуцын тухай хууль, Байгууллагын нуцын тухай хууль, Цагдаагийн албаны тухай хууль, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомж, стандартуудыг мөрдлөг болгоно.

1.3.Улс, нийслэл, дүүргийн, орон нутгийн хөгжлийн сан, гадаадын зээл тусламж болон хувийн хэвшлийн санхүүжилтээр нийтийн эзэмшлийн гудамж, талбай, олон нийтийн газар, авто зам, нийтлэг үйлчилгээний хяналтын чиглэлээр хийгдэх телехяналтын системийг төлөвлөх, хэрэгжүүлэх, гүйцэтгэлд хяналт тавих, хүлээн авах, нэгдсэн сүлжээ, системд холбох, мэдээлэл ашиглах, засвар үйлчилгээг тогтмолжуулах харилцааг энэхүү журмаар зохицуулна.

ХОЁР.ТЕЛЕХЯНАЛТЫН КАМЕРЫН СИСТЕМИЙГ ТӨЛӨВЛӨХ

2.1. Нийслэлийн мэдээллийн технологийн асуудал хариуцсан байгууллага нь нийтийн эзэмшлийн гудамж, талбай, олон нийтийн газар, авто зам, нийтлэг үйлчилгээний хяналтын чиглэлээр Улс, нийслэл, дүүргийн, орон нутгийн хөгжлийн сан, гадаадын зээл тусламж болон хувийн хэвшлийн санхүүжилтээр хэрэгжүүлэх ирэх оны телехяналтын камерын төсөл, хөтөлбөрийн төлөвлөгөөг тухайн оны хоёрдугаар улиралд багтаан нутгийн захиргааны байгууллагуудаас ирүүлсэн саналыг үндэслэн нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулна.

2.2.Тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдаж амжаагүй болон шинээр зайлшгүй хийгдэх шаардлагатай телехяналтын камерын төсөл, хөтөлбөрүүдийг нийслэлийн мэдээллийн технологийн асуудал хариуцсан байгууллага болон Цагдаагийн байгууллагын телехяналтын асуудал хариуцсан нэгж хамтран тухайн оны гуравдугаар улиралд багтаан нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлж, төлөвлөгөөнд тусгана.

2.3.Телехяналтын камерын системийн төлөвлөгөөг нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулахад дараах үе шаттай явагдана.

2.3.1.Нийслэлийн мэдээллийн технологийн асуудал хариуцсан байгууллага нь ирэх онд нийтийн эзэмшлийн гудамж, талбай, олон нийтийн газар, авто зам, нийтлэг үйлчилгээний хяналтын чиглэлээр телехяналтын камер суурилуулах хэрэгцээ шаардлагын саналыг тухайн оны 02 дугаар сарын 01-ний өдрийн дотор дараах байгууллагуудаас авна:

2.3.1.1.Олон нийтийн болон барилга, байгууламжийн аюулгүй байдлыг хангах, Цагдаагийн албаны тухай хуулиар хүлээсэн үүргийг хэрэгжүүлэх чиглэлээр ашиглах телехяналтын камерын хэрэгцээ шаардлагын саналыг Цагдаагийн байгууллагын телехяналтын асуудал хариуцсан нэгжээс;

2.3.1.2.Цагдаагийн байгууллагын телехяналтын асуудал хариуцсан нэгж нь нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагаас;

2.3.1.3.Нийтлэг үйлчилгээний чиглэлээр Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба болон Шуурхай удирдлага, зохицуулалтын төвөөс;

2.3.1.4.Авто замын хяналтын чиглэлээр Улаанбаатар хотын Замын хөдөлгөөний удирдлагын төвөөс;

2.3.2.Нийслэлийн мэдээллийн технологийн асуудал хариуцсан байгууллага нь ирэх оны камерын хэрэгцээ шаардлагын дагуу дараах мэргэжлийн байгууллагуудтай хамтран техникийн тодорхойлолт, технологийн шийдэл, зураг төслийг тухайн оны 2 улиралд багтаан боловсруулсан байна.

2.3.2.1.Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл, шуурхай удирдлагын төв;

2.3.2.2.Улаанбаатар хотын Шуурхай удирдлага, зохицуулалтын төв;

2.3.2.3.Улаанбаатар хотын Замын хөдөлгөөний удирдлагын төв;

2.3.3.Телехяналтын камерын хяналтын цэгийг төлөвлөхдөө Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, Аж ахуй нэгжийн тусгай зөвшөөрлийн тухай хууль, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/120 дугаар тушаалаар батлагдсан "Барилга байгууламжийн гадна орчны аюулгүй байдлыг хангах зорилгоор ашиглаж байгаа дүрс бичлэгийн техник, хэрэгслийг цагдаагийн байгууллагын мэдээллийн нэгдсэн сүлжээнд холбох журам"-ын хүрээнд суурилуулсан аж ахуйн нэгж байгууллагын гадна орчны телехяналтын камерын хяналтын цэгтэй давхцахгүйгээр зохион байгуулна.

2.4.Телехяналтын камерын системийг төлөвлөхдөө орчны гэрэлтүүлэг, цахилгаан, шилэн кабел болон дэд бүтцийг давхар шийдвэрлэнэ.

2.5.Төлөвлөж буй телехяналтын камерын систем нь манай орны эрс тэс уур амьсгалд тохирсон, стандартад нийцсэн байх ба тусгай зориулалтын камерын техникийн тодорхойлолтод олон улсын стандартыг мөрдлөг болгон ашиглаж болно.

ГУРАВ. ГҮЙЦЭТГЭЛД ХЯНАЛТ ТАВИХ, ХЭРЭГЖҮҮЛЭХ

3.1.Батлагдсан төлөвлөгөө, төсвийн хүрээнд төслийн захиалагч байгууллага нь энэ журмын 2.3.2-т заасан техникийн тодорхойлолт, шийдэл, зураг төслийн дагуу гүйцэтгэх, хүлээн авах ажиллагааг зохион байгуулна.

3.2.Гүйцэтгэгч байгууллага нь хэрэгжүүлж буй телехяналтын төсөл хөтөлбөрийг гүйцэтгэхдээ мэргэжлийн байгууллагын гаргасан техникийн тодорхойлолт, шийдэл, ажлын зурагтай танилцаж хэрэгжүүлэх.

3.3.Захиалагч батлагдсан техникийн тодорхойлолт, шийдэл, ажлын зураг, төсвийн хүрээнд хийгдэж байгаа эсэхэд хяналт тавьж, зөрчлийг тухай бүр арилгуулна.

3.4.Хяналтын цэг, телехяналтын камер, дагалдах тоног төхөөрөмжүүдэд өгөх дугаар, нэгдсэн систем, сүлжээнд холбогдох хаяг /IP address/-ийг Цагдаагийн байгууллагын телехяналтын асуудал хариуцсан нэгж олгоно.

ДӨРӨВ. АШИГЛАЛТАД ХҮЛЭЭН АВАХ

4.1.Телехяналтын камерын системийн төслийг дараахь үе шаттай хүлээн авна.

4.1.1.Гүйцэтгэгч тал нь телехяналтын камерын системийг ашиглалтад хүлээлгэж өгөхдөө төслийн хүрээнд суурилуулсан тоног төхөөрмжийн бүртгэл,

ажлын зураг, тоног төхөөрөмжийн бүртгэлийн дугаар, холбогдох баримт бичиг, гарын авлагыг Захиалагч талд хүлээлгэн өгнө.

4.1.2.Нийслэлийн мэдээллийн технологийн асуудал хариуцсан байгууллага тухайн системийг ашиглах мэргэжлийн албадтай хамтарсан техникийн комисс байгуулж, энэ журмын 2.3.2-т заасан техникийн тодорхойлолт, шийдэл, ажлын зураг төслийн дагуу хийж гүйцэтгэсэн эсэхийг шалгаж дүгнэлт гаргах, гаргасан дүгнэлтийг үндэслэн Захиалагч байгууллага хүлээн авна.

4.1.3.Энэ журмын 4.1.2-т заасан дүгнэлтэд техникийн тодорхойлолт, шийдэл, ажлын зургийн дагуу хийгдсэн талаар тусгана.

4.1.4.Байнгын ашиглалтад оруулах комиссын бүрэлдэхүүнд тухайн системийг ашиглах байгууллага, мэргэжлийн албадын төлөөллийг оруулна.

- Нийслэлийн Мэдээлэл, технологийн газар,
- Цагдаагийн байгууллагын телехяналтын асуудал хариуцсан нэгж,
- Улаанбаатар хотын Замын хөдөлгөөний удирдлагын төв НӨҮГ,
- Улаанбаатар хотын Шуурхай удирдлага, зохицуулалтын төв ОНӨТҮГ

4.1.5.Байнгын ашиглалтад оруулах комисс 4.1.3-т заасан дүгнэлтийг харгалзан шийдвэр гаргана.

4.1.6.Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журмын 3.2.3, 3.2.4-т заасныг үндэслэн телехяналтын системийн төслийн хүрээнд тавигдсан техник, тоног төхөөрөмжийн эзэмшигчийг тодорхойлж хүлээн авна.

4.1.7.Нийслэлийн мэдээллийн технологийн асуудал хариуцсан байгууллага нь захиалагчаас ирүүлсэн хүсэлтийн дагуу камерын бүртгэл мэдээллийг ажлын 5 хоногийн дотор орон зайн мэдээллийн системд суурилсан хот байгуулалтын дундын мэдээллийн санд бүртгэнэ.

4.2.Энэ журмын 4.1.2, 4.1.4-т заасан комиссын дүгнэлтээр хүлээн авсан телехяналтын камерын төслийг Цагдаагийн байгууллагын телехяналтын камерын нэгдсэн сүлжээнд тус газрын телехяналтын асуудал хариуцсан нэгж холбоно.

4.3.Энэ журмын 4.1.2-т заасныг хангаагүй телехяналтын камерын системийг хүлээн авахыг хориглоно.

4.4.Энэ журмын 2.3.2-т заасан техникийн тодорхойлолт, технологийн шийдэл, зургийн шаардлага хангаагүйгээс үүсэх эдийн засгийн болон бусад үр дагаварыг гүйцэтгэгч тал хариуцна.

4.5.Нийслэл хотын гудамж, зам талбайг хянах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор аж ахуй нэгж, байгууллагын камеруудыг стандартын шаардлага хангасан тохиолдолд Цагдаагийн байгууллагын телехяналтын камерын нэгдсэн сүлжээнд тус газрын телехяналтын асуудал хариуцсан нэгж холбож болно.

4.6.Орон сууц, гэр хорооллын гудамж, нийтийн эзэмшлийн талбайд суурилуулсан стандартын шаардлага хангасан хяналтын камеруудыг Цагдаагийн байгууллагын телехяналтын камерын нэгдсэн сүлжээнд тус газрын телехяналтын асуудал хариуцсан нэгж холбож болно.

ТАВ. НИЙСЛЭЛИЙН НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГУУДЫН ТЕЛЕХЯНАЛТЫН КАМЕР СУУРИЛУУЛАХАД БАРИМТЛАХ НИЙТЛЭГ ҮҮРЭГ

5.1.Нийслэлийн нэгдсэн телехяналтын камерын системийг төлөвлөх, ашиглах, зохион байгуулах ажлыг нийслэлийн мэдээллийн технологийн асуудал хариуцсан байгууллага хариуцан ажиллана.

5.2.Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд нь Цагдаагийн албаны тухай хуулийн 65 дугаар зүйл, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 9 дүгээр зүйл, Аж

ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11 дүгээр зүйл болон гадна орчны аюулгүй байдлыг хангаж телехяналтын камер суурилуулна.

5.3.Энэ журмын 5.1-д заасан камерыг суурилуулахдаа MNS 6423:2019 стандарт, цагдаагийн байгууллагын телехяналтын камерын нэгдсэн сүлжээнд холбохдоо ЦЕГ-ын даргын 2017 оны А/120 дугаар тушаалаар баталсан "Барилга байгууламжийн гадна орчны аюулгүй байдлыг хангах зорилгоор ашиглаж байгаа дүрс бичлэгийн техник, хэрэгслийг цагдаагийн байгууллагын мэдээллийн нэгдсэн сүлжээнд холбох журам"-ыг баримтална.

5.4.Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.6-д заасан цагдаагийн байгууллагын саналыг Цагдаагийн байгууллагын телехяналтын асуудал хариуцсан нэгжээс авна.

5.5.Нийслэлийн мэдээллийн технологийн асуудал хариуцсан байгууллага нь камерын мэдээллийн санг Орон зайн мэдээллийн системд суурилсан Хот байгуулалтын дундын мэдээллийн санд нэгтгэн, хариуцан ажиллана.

5.6.Энэхүү журмын 5.2-т заасныг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд Цагдаагийн байгууллагын телехяналтын асуудал хариуцсан нэгж хяналт тавина.

5.7. Улс, нийслэл, дүүргийн, орон нутгийн хөгжлийн сан, гадаадын зээл тусламж болон хувийн хэвшлийн санхүүжилтээр хэрэгжүүлсэн хяналтын камерууд нь стандартын шаардлага хангасан тохиолдолд Цагдаагийн газрын телехяналтын нэгдсэн системд холбож болно.

5.8. Гудамж, талбай, олон нийтийн газар, авто зам, нийтлэг үйлчилгээний хяналтын камерын систем, тоног төхөөрөмжүүдийн хэвийн найдвартай ажиллагаа, мэдээллийн аюулгүй байдлыг өмчлөгч байгууллага бүрэн хариуцана.

ЗУРГАА. ТЕЛЕХЯНАЛТЫН КАМЕРЫН НЭГДСЭН СИСТЕМ, ДҮРС БИЧЛЭГИЙН САНГИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

6.1.Телехяналтын камерын нэгдсэн систем нь телехяналтын камерын бие даасан системүүдийг мэдээллийн аюулгүй байдлыг хангасан сүлжээнд нэгтгэн зохион байгуулж, удирдлага зохицуулалт хийх боломжийг бүрдүүлнэ.

6.2.Телехяналтын дүрст мэдээллийг ашиглагч байгууллагын дүрс бичлэг хадгалах төхөөрөмжид, шаардлагатай тохиолдолд мэдээллийн аюулгүй байдал бүрэн хангагдсан байгууламжид нөөц сан үүсгэн хадгалж болно.

ДОЛОО. ТЕЛЕХЯНАЛТЫН КАМЕРЫН НЭГДСЭН СИСТЕМИЙН МЭДЭЭЛЛИЙГ АШИГЛАХ, СОЛИЛЦОХ

7.1.Телехяналтын камерын нэгдсэн системд дараах байгууллагууд холбогдож, хэрэгцээндээ үндэслэн ашиглах эрхтэй:

7.1.1 Цагдаагийн ерөнхий газар;
7.1.2 Тагнуулын ерөнхий газар;
7.1.3 Нийслэлийн Онцгой байдлын алба;
7.1.4 Нийслэлийн Түргэн тусламжийн төв;
7.1.5 Нийслэлийн Мэдээлэл, технологийн газар;
7.1.6 Улаанбаатар хотын шуурхай удирдлага, зохицуулалтын төв;
7.1.7 Замын хөдөлгөөний удирдлагын төв.

7.2.Энэ журмын 7.1-д заасан байгууллага хооронд дүрст мэдээлэл солилцох гэрээ байгуулж хэрэгжүүлнэ. Гэрээнд системд хандах эрх бүхий ажилтны мэдээлэл, эрхийн зохицуулалт, нууцлал, аюулгүй байдлын талаар тусгана.

7.3.Энэ журмын 7.1-т зааснаас бусад байгууллага телехяналтын камерын нэгдсэн системээс мэдээлэл авах тохиолдолд эзэмшигч байгууллагад албан бичгээр хүсэлтээ өгнө.

НАЙМ. ТЕХНИКИЙН ҮЗЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭ, АРЧИЛГАА

8.1.Гудамж, талбай, олон нийтийн газар, авто зам, нийтлэг үйлчилгээний хяналтын камерын чиглэлээр арчилгаа, техникийн үзлэг үйлчилгээний төлөвлөгөө, зардлыг Орон зайн мэдээллийн системд суурилсан хот байгуулалтын дундын мэдээллийн санд тулгуурлан тооцож, өмчлөгч байгууллага нь урсгал зардалдаа суулгуулж, ашиглалт, үйлчилгээ хариуцах аж ахуйн нэгж, байгууллагыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулж гэрээ байгуулан ажиллана.

8.2. Гудамж, талбай, олон нийтийн газар, авто зам, нийтлэг үйлчилгээний хяналтын камеруудыг холбосон шилэн кабелын засвар үйлчилгээний зардлыг тухайн өмчлөгч байгууллага нь урсгал зардалдаа суулгуулж, ашиглалт, үйлчилгээг бүрэн хариуцан холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулна.

8.3. Гудамж, талбай, олон нийтийн газар, авто зам, нийтлэг үйлчилгээний хяналтын камерын чиглэлээр засвар үйлчилгээг үзүүлэхдээ энэхүү журмын 4.1 дэх заалтыг хангаж ажиллана.

8.4.Энэ журмын 8.1-т заасны дагуу гэрээ байгуулахдаа нийслэлийн мэдээллийн технологийн асуудал хариуцсан байгууллага, Цагдаагийн байгууллагын телехяналтын асуудал хариуцсан нэгжийн санал, техникийн дүгнэлтийг үндэслэн гүйцэтгэлийг улирал бүр тооцох талаар зохицуулалтыг тусгана.

8.5.Телехяналтын камер, дагалдах тоног төхөөрөмж нь үйлдвэрлэгчийн баталгаат хугацаа нь дуусан тохиолдолд техникийн дүгнэлтэд үндэслэн ашиглалтаас хасах, шинэчлэх саналыг Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газарт хүргүүлнэ.

ЕС.ХАРИУЦЛАГА

9.1.Энэхүү журмыг зөрчсөн тохиолдолд холбогдох хууль, тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэж, учирсан хохирлыг нөхөн төлүүлнэ.

_o0o_